



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/175

Мандалговь

Б.Хүрэлчөдөрийн зээл төлөлтийн  
хуваарьт өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “д”, 29.1.6. ”л”, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтын 3.5, 3.5.3, 5.3.4, Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 72 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын 11.2, иргэн Б.Хүрэлчөдөрийн хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Сум хөгжүүлэх сан”-аас 2020 онд “Арьс нэхий элдэх” зориулалтаар зээл авсан иргэн (Б.Хүрэлчөдөр)-ийн үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, түүхий эд нь 2021 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хүчтэй салхи, шуурганы улмаас байгалийн гамшигт нэрвэгдэн хохирол үүссэн нөхцөл байдлыг харгалзан үзэж үндсэн зээлийн төлөлтийг 2023 оны 5 сарын 2-ны өдөр хүртэл 19 сарын зээл төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулахыг СХС-ийн нарийн бичиг ЖДҮГТХМэргэжилтэн /Ш.Бямба/, ня-бо /Н.Саранзаяа/ нарт зөвшөөрсүгэй.

2. Өнөөгийн байдлаар үүссэн зээлийн хүү, алдангыг бүрэн төлүүлж, үндсэн зээлийн үлдэгдэл төлөлтийг сунгаж, нэмэлт гэрээ байгуулахыг СХС-ийн нарийн бичиг ЖДҮГТХМэргэжилтэн /Ш.Бямба/, ня-бо /Н.Саранзаяа/ нарт даалгасугай.

3. Үйлдвэрлэлийн байраа сэргээн тохижуулж, зээлийг зориулалтаар ашиглан, нэмэлт гэрээний хавсралтын дагуу хугацаанд нь төлж барагдуулахыг иргэн (Б.Хүрэлчөдөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ